

**ШИНЭ КОРОНАВИРУСТ (COVID-19)
ХАЛДВАР ОРЖ ИРСЭН ҮЕД ТАРХАХ
ЭРСДЭЛИЙН 1 ДАХЬ ҮЕ ШАТНЫ
САЛБАР ДУНДЫН ҮНЭЛГЭЭ**

Дорноговь аймаг

2020.02.21

Эрсдэлийн үнэлгээний багт:

1. Аймгийн Засаг даргын тамгын газар
2. Эрүүл мэндийн газар
3. ЗТДГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс
4. ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс
5. Онцгой байдлын газар
6. Мэргэжлийн хяналтын газар
7. Цагдаагийн газар
8. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
9. Хүнс, хөдөө аж ахуйн газар
10. Авто тээврийн төв

[Шинэ коронавируст халдвар СОУЮ-19, БНХАУ], [Монгол]

Эрсдэлийн үнэлгээний асуулт:

Үнэлгээний огноо болон хувилбар -1	Үнэлгээ	Тэргүүлсэн байгууллага:	Хамтран оролцсон байгууллага:
2020.02.21	Явцын үнэлгээ	ЭМГ	ЭМГ, ЗДТГ, ОБГ, МХГ, ХХААГ, БХБХБГ, ЦГ, АТТ

Шинэ коронавируст (СОУЮ-19) халдвар орж ирсэн үед тархах эрсдэл ямар байх вэ?

Монгол Улсын Шадар сайдын 2017 оны А/08 тоот тушаалаар батлагдсан Эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээг салбар хоорондын байгууллагууд хамтран хийв.

Эрсдэлийн үнэлгээний дүн: Маш өндөр эрсдэлтэй

Тодорхой	Бага	Дунд	Өндөр	Маш өндөр
Өндөр	Бага	Дунд	Өндөр	Маш өндөр
магадлалтай	Бага	Дунд	Өндөр	Маш өндөр
Магадлалтай	Бага	Дунд	Өндөр	Маш өндөр
Магадлалгүй Маш	Бага	Дунд	Өндөр	Маш өндөр
ховор	Бага	Дунд	Өндөр	Маш өндөр

Эрсдэлийн матриц магадлалын түвшинг тогтоох

1. Үйл явдал нь улсын хэмжээнд заавал мэдээлэх тохиолдол мөн үү?

Тийм: Шинэ Коронавируст халдвар нь короновирусийн шинэ хэвшинжээр үүссэн хүний халдварт өвчин юм. Олон хүн өвдөж нас барж байгаа учраас заавал мэдээлэх ёстой.

2. Энэ үйл явдал өмнө нь бүртгэгдэж байгаагүй шинэ, шалтгаан тодорхойгүй тохиолдол мөн үү?

Тийм: Сайн судлагдаагүй, өмнө нь бүртгэгдээгүй шинэ вирусийн халдвар гэж үзсэн. Шалтгаан нь тодорхойгүй уушигны хатгалгаагаар олон хүн зэрэг БНХАУ-д өвчилсөн. Дэлхий дахинд шинэ вирус гэж үзсэн

3. Тухайн орон нутгийн хил хязгаараас халих боломжтой юу?

Тийм: Уг халдвар нь амьсгалын замаар халддаг гэсэн боловч сүүлийн үеийн мэдээгээр янз бүрийн байдлаар халдвар авсан хүний өвчлөл олон улс оронд бүртгэгдээд байгаа. Хятад улстай манай аймаг хил залгаа оршдог, хил нэвтрэх 2 том боомт ажилладаг

4. Хүнээс хүнд дамжин тархах эрсдэлтэй юу?

Тийм: Шинэ коронавирусийн халдвар авсан өвчтөнүүдэд тусламж, үйлчилгээ үзүүлж байсан эрүүл мэндийн ажилтнууд өвдсөн. Өвчтэй хүнтэй уулзсан хүмүүс, тэр бүс нутагт аялсан хүмүүсээс халдвар илэрсэн тухай ЭМЯ-наас мэдээлэл өгсөн.

5. Тухайн үйл явдлыг лабораторийн шинжилгээгээр баталгаажуулах боломжтой уу?

Тийм: Аймгийн хэмжээнд шинжилгээний сорьц авах материал 20 /Сайншандад 15, Замын Үүдэд 5 ширхэг/ ширхэг материал бэлэн байна. Эмч мэргэжилтнүүдийг сорьц авах арга барилд сургасан. Шаардлагатай тохиолдолд нэмэлт сорьцын материалыг 24 цагийн дотор галт тэргээр татах боломжтой

6. Тухайн үйл явдалд өртсөн хүний тоо тодорсон уу?

Тийм: Аймгийн хувьд өнөөдрийн байдлаар нийт 12 сэжитэй тохиолдлуудыг илрүүлж тандалт судалгаа хийж оношийг үгүйсгэсэн. Хавьтлын 226 хүнийн тусгаарлан тандалт хийснээс өнөөдрийн байдлаар 104 хүнийг Замын Үүд суманд тусгаарлан хянаж байна. Гэхдээ тэмдэг илрээгүй хүмүүст халдвар байгаа эсэх тодорхойгүй.

7. Өвчний нууц үеийн хугацаа урт уу?

Тийм: ДЭМБ-ын түр зөвлөмжөөр нууц үеийн хугацаа 14 хоног байна. Зарим судалгаар 24 хоног хүртэл байх боломжтой байна.

8. Тухайн газар болон хил залгаа нутагт уг халдвараар амьтны өвчлөл хорогдол бүртгэгдсэн үү?

Мэдэхгүй: Тодорхой мэдээлэл байхгүй.

9. Урьд нь ижил төрлийн үйл явдал тохиолдож байсан уу?

Тийм: манай аймгийн хувьд 2003 онд коронавирусээр үүсгэгдсэн SARS халдварын үед тодорхой арга хэмжээнүүдийг авч ажиллаж байсан.

10. Өвөрмөц урьдчилан сэргийлэлт бий юу?

Үгүй: Вакцин болон вирусийн эсрэг эм судалгааны шатандаа явж байна.

11. Хариу арга хэмжээ шуурхай авах чадавхтай эсэх?

Үгүй: Мэргэжлийн байгууллагууд тодорхой хэмжээгээр бэлэн байдлаа хангаж ажиллаж байна.

- Хилийн мэргэжлийн хяналтын газраас орж ирж буй зорчигчдод эрүүл мэндийн хяналт тавьж байна.
- Орон нутгийн телевизээр дамжуулан иргэдийг үнэн зөв мэдээллээр хангаж байна.
- Сэрэмжлүүлэг мэдээллийг нийгмийн сүлжээгээр болон гар утсанд мессэжээр хүргэж байна.
- АОК хариу арга хэмжээ авч ажиллаж байна. Хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлэх, эмнэлгийн тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэхэд тодорхой хэмжээгээр хөрөнгө санхүүг шийдвэрлэсэн. Гэвч өвчлөл бүртгэгдсэн үед нэн тэргүүнд халдварын сэргийлэлт, хяналтын арга хэмжээг чангатгах, эмнэлгийн ажилчид, хууль хүчний байгууллага, хилийн мэргэжилийн хяналтын албаны ажилчдыг халдвараас хамгаалах шаардлагатай тул хувийн хамгаалах хэрэгсэл дутагдалтай, хүрэлцээ хангамж муу байгаа.
- Өвчтөнийг хүндрэлээс сэргийлэх, эмнэлзүйн менежментийг сайжруулах шаардлагатай багаж тоног төхөөрөмжийн хангалт хүрэлцээ муу байгаа.
- Халдвар авсан иргэдийн хамгийн түрүүнд хандах Замын Үүд, Ханги мандалын боомтын Эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдал, хувийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалт хүрэлцээ муу.
- Хил, гааль, онцгой байдал, мэргэжлийн хяналтын байгууллагуудын ажилчдын хувийн хамгаалах хэрэгслийн хангамж, хүрэлцээ муу. Хүний нөөц дутагдалтай
- Дотоодын зорчигч тээвэрт халуунтай хүн илэрсэн тохиолдолд нэгдсэн зохицуулалт бүрдээгүй.
- Халдваргүйтгэлийн бодис болон амны хаалт хүрэлцээгүй.
- Салбар дундын хариу арга хэмжээ авах төлөвлгөөний хэрэгжилт хангалтгүй.
- Орон нутгийн төсвийн орлого 43%-аар тасарсан, нөхөх цаг хугацаа байхгүй.
- Хавьтлуудыг олноор түр тусгаарлах байр хүрэлцэхгүй

12. Болсон үйл явдал цаашид даамжрах уу?

Тийм: Шинэ халдвар учраас хүн бүр мэдрэг, судалгаагаар 1 хүн 2,7-5 хүнд халдвар тараах эрсдэлтэй.Тархалт өндөртэй

13. Эмнэлзүйн явц хүнд үү?

Мэдэхгүй: Ихэнх хүмүүс өвчний хүнд хөнгөн явцын талаар мэдээлэл муутай байна.

14. Үүсгэгчийн хоруу чанар өндөр үү?

Тийм: Өвчлөл бүртгэгдэж буй БНХАУ-д өртөлт хүндрэл, нас баралтын тоо нэмэгдэж байна. Үүсгэгчийг судалж байгаа. Вирусийн эсрэг өвөрмөц эм гараагүй байна. Өвчлөл амьсгалын замын дутагдал, бөөрний дутагдалд хүргэж байна

15.Эмнэлзүйн шинж тэмдэг тодорхой юу?

Тийм: Амьсгалын замын болон хоол боловсруулах замын халдварын шинж тэмдэг илэрч байна.

Эрсдэлийн матриц үр дагаврын түвшин тогтоох

1. Бүртгэгдсэн тохиолдолд үйл явдлын нөхцөл байдал хүндрэх үү?

Тийм: Шинэ вирусийн учир хүн бүр мэдрэг өвчлөх эрсдэл өндөр, иргэдийн мэдлэг ойлголтын түвшин амьдралын хэв маягт нөлөөлнө. Нэмэгдэл хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилга байгууламж зэрэг хариу арга хэмжээг шуурхай авах нөхцөлд бүрдээгүй чадавх сул.

Орон нутгийн хэмжээнд орох, гарах хяналтын постууд ажиллуулж байгаа бөгөөд үйл ажиллагаа бүрэн жигдрээгүй байна. Хяналтын постоор гарч байгаа тээврийн хэрэгсэл болон зорчигчийн тоог хянах боломжгүй, сар шиний баяр дөхсөн учраас иргэдийн хөдөлгөөнийг хянахад хүндрэлтэй. Дотоодын шилжилт хөдөлгөөнд төмөр зам, автомашинаар зорчих иргэдэд хяналт тавихад хүндрэл үүсэж байна. Мөн иргэд баталгаатай бус замаар хувийн машинаар зорчих эрсдэлтэй. Алслагдсан хөдөөгийн малчдын хөдөлгөөнийг хянах боломжгүй.

Сэжигтэй үйл явдал илэрсэн тохиолдолд хяналтанд авч тусгаарлах байрны асуудал хүндрэлтэй, үүрэг гүйцэтгэх байгууллагуудын зохицуулалт дутагдалтай.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх, хуулийн байгууллагын шаардлагыг биелүүлэхгүй байх, гэмт хэргийн тоо нэмэгдэх эрсдэл үүсэж болзошгүй.

2. Үйл явдал хурдан даамжирч байна уу?

Тийм: Замын Үүд боомтоор ачаа тээвэрлэлт үргэлжилж байна. Замын Үүд суманд хамгийн олон сэжигтэй тохиолдол болон хавьтлыг тусгаарласан.

3. Олон хүн өртөх үү ?

Тийм: Шинэ халдвар учраас хүн ам дархлаагүй. Халдварын тархалт нэмэгдэж байгаа, эх уурхай дамжих зам тодорхойгүй, шинж тэмдэг балархай байгаа. Мөн ажиглалтанд авах хүний тоо /226/ нэмэгдсэн.

4. Өртсөн хүмүүс эрүүл мэндийн байгууллагад яаралтай хандах боломжтой юу?

Тийм: Иргэд анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг аймаг, нийслэлийн бүх шатны эрүүл мэндийн байгууллагаас авах боломжтой. Эрүүл мэндийн байгууллагууд уртасгасан, 24 цагийн бэлэн байдалд ажиллаж, иргэдэд 24 цагийн нээлттэй утсаар зөвлөмж, мэдээлэл өгч байна.

5. Шалган нэвтрүүлэх товчоо бүртгэл, хяналтын чадавхтай эсэх /дотоод/ ?

Үгүй: Босоо тэнхлэгийн авто зам дээр хянах пост ажиллаж иргэдийн халууныг үзэж байна. Гэвч тусгаарлах өрөө, хүний нөөц, багаж хэрэгсэл хангалтгүй байна.

6.Олон нийтийн анхаарлыг татаж, түгшүүр төрүүлэх эрсдэлтэй юу?

Тийм: Нийгмийн сүлжээгээр буруу, ташаа мэдээлэл тараагдаж байгаатай холбоотой иргэдийн айдас нэмэгдэж байна.

7.Хариу арга хэмжээ авах улс/орон нутгийн чадавх нөөц хүрэлцээтэй юу?

Үгүй: Халдвар бүртгэгдсэн тохиолдолд бүрдүүлсэн нөөцийг зарцуулах боловч, хүн амын дунд халдварын тархалт нэмэгдэх, өвчтөн хүндрэх, эрүүл мэндийн байгууллагын ачаалал нэмэгдэх, эрүүл мэндийн эмч, мэргэжилтэн өвчилсөн тохиолдолд нэмэлт хүч, нөөцийг дахин бүрдүүлэх, дайчлах хэрэгтэй болно. Нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд аймгийн хэмжээнд нөөц хүрэлцэхгүй байна. Санхүү бүрдсэн ч хамгаалах хувцас хэрэглэл тоног төхөөрөмжийн олдоц муу.

8. Хариу арга хэмжээний зардал өндөр үү?

Тийм: Урьдчилсан тооцоогоор 1 тэрбум 71 сая төгрөгийн тооцоо гараад байна. Одоогоор 166,0 сая төгрөгийн зардал гараад байна. Өнөөдрийн байдлаар Замын Үүд суманд тусгаарлан ажиглалтанд байгаа 104 хүнд зарцуулагдах зардлууд тооцоонд ороогүй учраас цаашид зардал нэмэгдэнэ.

9.Хариу арга хэмжээнд нэмэлт хүч хэрэгсэл, тусламж шаардлагатай юу?

Тийм: Одоогийн байгаа нөөц дээр хүн хүч, техник хэрэгсэл нэмэлтээр шаардагдана. Коронавирусийн халдварын тархалт их тул эмч, эмнэлгийн ажилтнаас гадна сайн дурын ажилтан, техник тоног төхөөрөмж, тусгаарлах байр зэрэг нэмэлт хүч хэрэгслийг дайчлах шаардлага тулгарч болно. Олон улсын байгууллагууд, гадаад улс орноос хүмүүнлэгийн тусламж хүсэх нөхцөл үүсэж болзошгүй.

10.Нийгэмд эмх замбараагүй байдал үүсэх үү?

Тийм: Хулгай дээрэм, тонуул гарч болзошгүй. Иргэдэд зөв мэдээлэл хүргэхгүй бол нийгэмд эмх замбараагүй байдал үүсэх эрсдэлтэй. Мөн бодит бус мэдээллээс үүдэн бараа, бүтээгдэхүүний зохиомол үнийн хөөрөгдөл үүсэж болзошгүй.

11.Тухайн орон нутгийн зам харилцаа, үйлдвэрлэл, үйлчилгээний ердийн горимд нөлөөлөх үү?

Тийм: Одоогоор олон нийтийг хамарсан үйл ажиллагааг хориглосон. Худалдаа, үйлчилгээний газруудын цагийн хуваарьт өөрчлөлт орсон. ЭМБ-ын ажиллагсад уртасгасан цагаар ажиллаж байна

12.Нас баралтын түвшин өндөр үү

Үгүй/мэдэхгүй: Нас баралтын түвшин 2.5% байгаа нь 5АГС5 (%) МEGC5 (30-40%), Эболагийн (50%) халдвартай харьцуулахад бага_ Дэлхийн бусад улс оронтой харьцуулахад хүн амын дийлэнхийг хүүхэд залуус эзэлдэг. Энэ өвчнөөр өндөр настан, архаг өвчтэй хүмүүс нас барах нь илүү гэсэн мэдээлэлтэй байна.

13. Тухайн үйл явдалд чиглэсэн хариу арга хэмжээг авч эхэлсэн эсэх?

Тийм: Аймгийн хэмжээнд Засаг даргын захирамжаар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн. Аймгийн хэмжээнд шуурхай штаб байгуулан, Гамшгаас хамгаалах албыг 24 цагийн горимд шилжүүлэн бэлэн байдлыг ханган хариу арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

14. Хүрээлэн буй орчинд үзүүлэх эрсдэл өндөр үү?

Мэдэхгүй: Шинэ халдвар тул мэдээлэл хязгаарлагдмал байна

15. Лабораторийн шинжилгээний сорьцийн материалын нөөцтэй юу?

Тийм: Аймгийн хэмжээнд шинжилгээний сорьц авах материал 20 /Сайншандад 15, Замын Үүдэд 5 ширхэг/ ширхэг материал бэлэн байна. Эмч мэргэжилтнүүдийг сорьц авах арга барилд сургасан. Шаардлагатай тохиолдолд нэмэлт сорьцын материалыг 24 цагийн дотор галт тэргээр татах боломжтой

16. Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын орны ачаалал нэмэгдэх үү?

Тийм: Нэмэгдэнэ .Одоогоор Замын Үүдэд 25, Аймгийн нэгдсэн эмнэлэгт 40 ор дэлгэх, нөхцөлийг бүрдүүлээд байна. Бусад тасаг нэгжийн үйл ажиллагааг шилжүүлж нэмэлт орыг дэлгэсэн нь бусад эмнэлгийн үйл ажиллагаанд ачаалал нэмэгдүүлж байна. Аймгийн төвд Халдвартын зориулалтын эмнэлэг байхгүй, Замын үүдийн нэгдсэн эмнэлгийн халдвартын тасгийн байр, ор хүрэлцээгүй

17. Ус хөрсөнд хадгалагдаж, цаашид хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх боломжтой юу?

мэдэхгүй: Шинэ халдвар тул судлагдаж байна.Тодорхой мэдээлэл байхгүй

18. Тухайн орон нутаг/үндэстний соёл, ёс заншил, уламжлалын онцлогт нөлөөлөх үү?

Тийм: Уламжлалт сар шинийн баярыг олон нийтээр тэмдэглэн өнгөрүүлэхийг хязгаарласан. Нас баралт бүртгэгдвэл оршуулгын зан үйлээс үүдэлтэй эрсдэл үүсэж болзошгүй. Шашны зан үйл нөлөөлнө.

19. Хүн амд /өрх, хувь хүн/ эдийн засгийн дарамт үүсэх үү?

Тийм: Хувь хүн, өрх гэрт эдийн засгийн дарамт олон хэлбэрээр үүсэх магадлалтай.

Халдвараас урьдчилан сэргийлэхийн тулд дархлаа сайжруулах амин дэм, хувийн хамгаалалтын хэрэгсэл, халдваргүйтлэлийн материалд зарцуулах зардал нэмэгдэх, хорио цээрийн дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт хувь хүний болон өрхийн бизнесийн ажиллагаа саармагжих, хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал хязгаарлагдаж, орлого буурах магадлалтай,төсвийн орлогын бүрдүүлэлт буурснаар хүн амын амьжиргаанд сөргөөр нөлөөлнө

20. Шууд болон шууд бус байдлаар улс болон орон нутгийн эдийн засагт хүндрэл үүсэх үү?

Тийм: Орон нутгийн төсвийн орлого 43%-аар тасарсан нөхөн бүрдүүлэх цаг хугацаа байхгүй

ЗӨВЛӨМЖ

№	Арга хэмжээ	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч
1.	Засгийн газрын холбогдох шийдвэр, хэрэгжүүлж буй арга хэмжээ, ДЭМБ- аас өгч буй сэрэмжлүүлэг мэдээллийг нэг шугамаар масс мессежээр иргэдэд тогтмол хүргэх	ЭМГ	АОК, Гамшгаас хамгаалах албад
2.	Аймгийн хэмжээнд шинэ коронавирус /COVID-19/ өвчинтэй тэмцэх шаардлагатай нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах	АОК	Гамшгаас хамгаалах албад
3.	Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан үүрэг гүйцэтгэж байгаа бусад салбар, мэргэжлийн ангийн ажилтан, алба хаагчдад чиглэсэн сургалтыг тогтмол зохион байгуулах	ЭМГ	Гамшгаас хамгаалах албад
4	Манай улсад шинэ коронавирус /ОӨУЮ-19/-ийн халдвар зөөвөрлөгдөн орж ирсэн тохиолдолд дайчлан ажиллуулах хүн хүчийг сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангах	ЭМГ	Гамшгаас хамгаалах албад
5.	Салбар бүр коронавирус /COVID-19/- ийн халдварын дэгдэлт үүссэн тохиолдолд даван туулах <i>чадавхын</i> үнэлгээг 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор хийж гүйцэтгэх	Гамшгаас хамгаалах албад	
6.	Олон нийтийг хамарсан үйл ажиллагааг хязгаарлах, орон нутагт зорчих хөдөлгөөнийг бууруулахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх	Авто тээврийн төв Цагдаагийн газар	Сумдын Засаг дарга нар
7.	Шадар сайдын 2017 оны А/08 тоот тушаалаар батлагдсан Эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу аймгийн түвшинд шинэ коронавируст /COVID-19/ халдварын эрсдэлийн үнэлгээг 2020 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн дотор хийж гүйцэтгэх	АОК ЭМГ	Гамшгаас хамгаалах албад
8	Шинэ коронавирус /COVID-19/-ийн үед ажиллах орон нутгийн шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдийн үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Авто тээврийн төв	Цагдаагийн газар
9	Эмч, эмнэлгийн ажилтан, тусгай чиг үүрэг бүхий байгууллагын болон шалган нэвтрүүлэх цэгүүдэд ажиллах ажилтан, алба хаагчдын хөдөлмөр, хамгааллын хувцас хэрэглэл, тоног төхөөрөмж, амны хаалт, ариутгал, халдваргүйжүүлэлтийн болон урвалж бодис, шаардлагатай үед хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн судалгааг гаргаж, зардлыг шийдвэрлэх	Гамшгаас хамгаалах албад	АОК, Гамшгаас хамгаалах улсын албад

10.	Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуураар хангах, нөөцийг бүрдүүлэх, эмч мэргэжилтэнг чадавхжуулах, шинэ мэдээ, мэдээллээр тогтмол хангах, заавар зөвлөгөө өгөх	ЭМГ	Эрүүл мэндийн байгууллагууд
11	Аймгийн хэмжээнд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулах зааварчилгаа зөвлөмжийг хэрэгжүүлэх, төсөв санхүүг шийдвэрлэх	ЭМГ	АОК, Гамшгаас хамгаалах албад, Сумдын Засаг дарга нар
12	Гамшгаас хамгаалах тухай хуулинд заасан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүлээх эрх, үүргийн талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх	ОБГ	Сумдын Засаг дарга нар
13	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа гадаад дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгууллага, гадаад улс орноос хүсэх хүмүүнлэгийн тусламж /эм эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж/- ийн судалгаа тооцоог гаргаж, нэн шаардлагатай зүйлсийг эрэмбэлэн, шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах,	ЭМГ	АОК Гамшгаас хамгаалах улсын албад
14.	Орон нутгийн чиглэлд байрлах баталгаат бус авто замын хяналтыг сайжруулах, тухайн замаар зорчих иргэдийн хөдөлгөөнд хяналт тавих	Цагдаагийн газар Авто тээврийн төв	Сумдын Засаг дарга нар
15.	Боловсролын байгууллагад хязгаарлалтын дэглэм тогтоосон Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх	БСУГ	Сумдын Засаг дарга нар нар
16.	Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүнд зохиомол үнийн хөөрөгдөл үүсэхээс урьдчилан сэргийлэх, хяналт тавьж ажиллах	Хүнс, хөдөө аж ахуйн газар	МХГ
17.	Шинэ Коронавирус /COVID-19/-ийн халдвар бүртгэгдсэн улс орнуудаас шууд буюу дамжин ирэх зорчигчид, ачаа тээврийн мэдээлэл, зорчигчдын эрүүл мэндийг сайтар шалган улсын хил нэвтрүүлэх, энэ чиглэлээр холбогдох газруудад заавар, зөвлөгөө өгч ажиллах	Хилийн Мэргэжлийн хяналтын алба	Хилийн цэргийн 0108-р анги, Замын-Үүд дэх Гаалийн газар,
18	Хилийн боомт, гааль, шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдэд ажиллаж, үүрэг гүйцэтгэж байгаа ажилтан, алба хаагчдад коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр заавар зөвлөгөө өгч ажиллах, хамгаалалтын хувцас хэрэгслээр хангах	Хилийн Мэргэжлийн хяналтын алба Хилийн цэргийн 0108-р анги, Замын-Үүд дэх Гаалийн газар	АОК Гамшгаас хамгаалах улсын албад

19.	Цагаан сарын өдрүүдэд иргэд бөөнөөрөө айлд зочлох, хэсэг бүлгээр цуглахгүй байх чиглэлээр хяналт тавих	Цагдаагийн газар	Сумдын Засаг дарга нар
20.	Усан сан, спорт заал, бие бялдрыг хөгжүүлэх төвд үйлчлүүлэгсдийг нэг дор олноор цуглуулахаас сэрэмжилж цөөн хүнтэй	БСУГ	Сумдын Засаг дарга нар
21.	Олон нийтийг түгшээхгүйгээр үнэн зөв, бодитой мэдээллийг хүргэж ажиллах чиглэлээр зөвлөмж өгч, мэдээллийн бодит байдалд хяналт тавьж ажиллах,	АЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтэс	Цагдаагийн газар Тагнуулын газар
22.	Эрүүл мэндийн байгууллага шинэ коронавируст /COVID-19/ халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг иргэд олон нийтэд тогтмол, шуурхай хүргэж ажиллах	ЭМГ	ЭМБ-ууд
23.	Шалган нэвтрүүлэх товчоо, зам дундын хяналтын пост, бүртгэл хяналтын чадавхийг сайжруулах	Авто тээврийн төв	ЗТХЯ Цагдаагийн газар
24.	Сайншандын 50 ортой эмнэлэг, Замын Үүдийн 100 ортой эмнэлгийг ашиглалтанд авах арга хэмжээг шуурхай шийдвэрлүүлэх	ЭМГ	ЭМЯ АОК
25.	Хариу арга хэмжээнд нэмэлтээр авах хүн хүч, техник хэрэгслийн туслалцаа авах, санхүүгийн дэмжлэг хүсэх, холбогдох зардлыг шийдвэрлүүлэх	АОК	Гамшгаас хамгаалах улсын албад
26.	Нэмэлтээр дэлгэх ор зөөлөн эдлэлийн нөөцийг нэмэгдүүлэх, хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх	ЭМГ	ЭМЯ
27.	Хавьтал тусгаарлах зочид буудал, байрлуулах газруудтай гэрээ байгуулан, тооцоо судалгааг хийж, тодотгох,	ГХБХБГ	
28.	Хүнсээр хангах тооцоо судалгаа хийж гэрээг тодотгох	ХХААГ	
29.	Сургууль цэцэрлэгийн хоолны зардлын хэмнэлтийг ариутгал халдваргүйжүүлэлтийн зардалд шилжүүлэн зарцуулах	АЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс	
30.	Нийтийн эзэмшлийн талбай, орц, хонгил, айл өрхийн нүхэн жорлонд халдваргүйтгэл хийх	Сумдын засаг дарг нар	Ариутгал халдваргүйтгэлийн
31.	Голомтот ажиллаж буй ажилчдын илүү цагийн хөлсийг олгох	Гамшгаас хамгаалах албад	СЯ АЗДТГ-ын Санхүү төрийн

32	Сүм хийд, шашины байгууллагын үйл ажиллагаа, галын тахилга, уул овоо тахих, нар харах зан үйлийг хориглох	Сүм хийд, шашины байгууллага	Цагдаагийн газар МХГ
33.	Худалдаа, үйлчилгээний газруудын эрүүл ахуй халдвар хамгаалалын дэглэмд хяналт тавих	МХГ	